



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/12

Мандалговь

“Бүтээн байгуулалт, Иргэн төвтэй
Төрийн үйлчилгээ”-ний жилийн ажлын дэд
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын зорилт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр Бүтээн байгуулалтын ажлын дэд хэсэг, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг чанаржуулах чиглэлээр Иргэн төвтэй төрийн үйлчилгээний ажлын дэд хэсгийг зохион байгуулж, хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх ажлын дэд хэсгүүд жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллан тайланг 2019 оны 6, 12 дугаар сарын 1-ний дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Гурав. “Бүтээн байгуулалт, Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний жилийн ажлын дэд хэсгийг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн захиргааны улирдлагын хэлтэс (М.Цогзолмаа)-т, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т, ажлын явцад хяналт шинжилгээ, дотоод аудит хийж аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Г.Самданцоодол)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

486190082

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын
газрын даргын 2019 оны 13 сарын 11 өдрийн
27/12 тушаалын хавсралт



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Эдийн засгийн бодлого төлөвлөлт хариуцсан ерөнхий эдийн засагч
- Гишүүд: - Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Сайнцагаан сумын Засаг дарга
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд: - Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
- Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга